



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 51236

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/575 дугаар тушаалаар батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай”, Батлан хамгаалах сайдын 2020 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”-ийн 11.7.1, мөн сайдын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”, их сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны хоёрдугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ҮБХИС-ийн магистр, докторын сургалтын журмыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг 2024-2025 оны хичээлийн жилээс хэрэгжүүлэн ажиллахыг Эрдмийн сургууль /хурандаа Э.Нацагдорж/-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан их сургуулийн захирлын 2017 оны А/280 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Магистр, докторын сургалтын журмыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал хурандаа Б.Өлзийхуягт хариуцуулсугай.

ЗАХИРАЛ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



П.ЖАРГАЛАН

850100098

Боловсруулсан:х/ч.....*Б.Мөнхтулга*.....Б.Мөнхтулга
Хянасан:.....*М.Пүрэвсүрэн*.....М.Пүрэвсүрэн
Хянасан:хур.....*Б.Өлзийхуяг*.....Б.Өлзийхуяг
Хувь:01

ҮБХИС-ийн захиарын 2024 оны 06
дугаар сарын өдрийн дугаар
тушаалын хавсралт

ҮБХИС-ИЙН МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ

1117234741
УКД0139 9096868

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үндэсний батлан хамгаалахын их сургууль (цаашид “ҮБХИС” гэх)-д магистр, докторын сургалт эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ҮБХИС-ийн магистр, докторын сургалтын журам (цаашид “сургалтын журам” гэх) нь Дээд боловсролын тухай хууль, Засгийн газрын “Батлан хамгаалахын их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 156-р тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”, 2023 оны А/575 дугаар тушаалаар батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/144 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам”, А/146 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай, А/147 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”, “Үндэсний батлан хамгаалахын их сургууль”-ийн дүрэмд үндэслэнэ.

1.3. Магистр, докторын сургалтын зорилго нь боловсролын бакалаврын болон магистрын зэрэгтэй суралцагчдад батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлал, удирдахуйн ухаанаар ахисан түвшний боловсрол олгох сургалт зохион байгуулж, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй эзэмшүүлж, мэргэшсэн судлаач, эрдэмтдийг бэлтгэхэд оршино.

1.4. Эрдэм шинжилгээний ажил, сургалтыг батлан хамгаалах бодлого болон төрийн цэргийн байгуулалт, аюулгүй байдал судлал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагад нийцүүлж, чанарыг эрхэмлэх, инновац, мэдээллийн технологийн ололтод түшиглэх, суралцагсдын эрдэм судлалын эрх чөлөө, эрх ашгийг хүндэтгэн ил тод, нээлттэй байх нь магистр, докторын сургалтад баримтлах үндсэн зарчим болно.

Хоёр. Элсэлт

2.1. ҮБХИС-ийн магистр, докторын сургалтын элсэлтийг нэг ба есдүгээр сард 2 удаа зохион байгуулна. Элсэлтийн зарыг шалгалт эхлэхээс нэг сарын өмнө ҮБХИС-ийн цахим хуудас, “Соёмбо” сонин, олон нийтийн бусад мэдээллийн хэрэгсэлд байршуулан олон нийтэд хүргэнэ. Элсэлтийг Эрдмийн сургуулийн Сургалт, судалгаа хөгжүүлэлтийн алба (цаашид ССХА-гэх) зохион байгуулна.

2.2. Докторын хөтөлбөрийн судалгааны ажлын чиглэлийг Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс баримталж буй бодлого, чиглэлийн хүрээнд зарлана.

2.3. БХЯ нь тус яамны бодлого, захиалгаар докторын өдрийн ангид суралцах цэргийн албан хаагчдын элсэлтийг тусгай журмаар зохион байгуулна.

2.4. Магистрантур, докторантурт элсэгчийн голч дүн 2.7-оос доошгүй байна.

2.5. Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид нь дараах баримт бичиг бүрдүүлнэ. Үүнд:

- ✓ Өргөдөл;
- ✓ Төрийн албан хаагчийн 1 дүгээр маягт;
- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ✓ Бакалавр, магистрын дипломын хуулбар, хавсралтын хамт;
- ✓ 3х4 хэмжээний цээж зураг 2 ширхэг;
- ✓ Ажиллаж буй албан байгууллагаас суралцахыг зөвшөөрсөн тодорхойлолт;
- ✓ Цагдаагийн тодорхойлолт;
- ✓ Элсэлтийн хураамж.

2.6. Магистрантур, докторантурын элсэлтийн шалгалт нь гадаад хэл, мэргэжлийн шалгалтаас бүрдэх ба шалгалт нь бичгийн болон ярилцлага хэлбэрээр зохион байгуулагдана. Шалгалтын материалыг тэнхимүүд боловсруулж, Эрдмийн сургуулийн захирлаар баталгаажуулна. ССХАлба нь тэнхимийн профессор багш нартай хамтран элсэлтийн шалгалтыг зохион байгуулна.

2.7. Элсэлтийн шалгалтын мэргэжлийн хичээлээр 80-аас доошгүй оноо авсан элсэгчийг магистр, докторын сургалтад элсүүлнэ.

2.8. Элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчдийг шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн ҮБХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна. Тушаалд суралцах хөтөлбөрийн нэр, хэлбэрийг заана.

2.9. ҮБХИС-ийг бакалаврын зэрэгтэй, тэргүүний шилдэг төгсөгчдийг ҮБХИС-ийн магистрын сургалтад урилгаар, элсэлтийн шалгалтгүйгээр элсүүлнэ.

2.10. Элсэгч нь өмнө эзэмшсэн бакалаврын болон магистрын боловсролын чиглэлээс өөр чиглэлээр магистр, докторын хөтөлбөрт хамрагдахыг хүсвэл сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийн зөрүүг нөхөж, 12-18 багц цагийн бэлтгэл сургалтад хамрагдана. Бэлтгэл сургалтаар нөхөж үзсэн цагийг үндсэн сургалтын багц цагт тооцохгүй.

2.11. Элсэхийг хүссэн гадаадын болон харьяалалгүй иргэд бүртгүүлэхдээ энэ журмын 2.5-д зааснаас гадна гадаад паспорт, боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан бичигтэй байна.

Гурав. Сургалтын төлөвлөгөө

3.1. БШУЯ-аас олгогдсон тусгай зөвшөөрлийг үндэслэн тэнхимүүд ССХА-тай хамтран сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн ҮБХИС-ийн захирлаар батлуулж албажуулна.

3.2. Магистр, докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрийн агуулгад холбогдох индекс, хичээл бүрийн багц цаг, хичээл хоорондын уялдааг тусгаж, хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан байна.

3.3. Магистрын хөтөлбөр 30 багц цагаас доошгүй байна. Мэргэжлийн болон судалгааны магистрын чиглэлтэй байж болох ба сургалтын төлөвлөгөөний агуулга ялгаатай байна.

Мэргэжлийн суурь хичээл нийт 12 багц цаг байна. Үүнээс 6 багц цаг нь судалгааны арга зүй, загварчлал, оюуны өмчийн мэдлэг олгох хичээлүүд, 6 багц цаг нь тухайн хөтөлбөрийн чиглэлийн ахисан түвшний үндсэн хичээлүүд байна.

Мэргэшүүлэх хичээл 9 багц цагаас доошгүй, эрдэм шинжилгээний ажил 4 багц цаг, магистрын судалгааны ажил 5 багц цаг байна. Эрдэм шинжилгээний ажлын 4 багц цагийг харьяалах тэнхимийн даргаар тооцоолж баталгаажуулна.

Зөвхөн Төрийн удирдлага магистрын хөтөлбөрөөр суралцагч нь магистрын ажил бичээгүй тохиолдолд нийт 32 багц цаг судлах ба үүнээс мэргэжлийн суурь 12 багц, мэргэшүүлэх хичээлээс 15 багц цаг, мэргэжлийн дадлага 5 багц цагыг судална.

3.4. Докторын хөтөлбөр нь 60 багц цагаас доошгүй байна.

Мэргэжлийн суурь хичээл 12 багц цаг, мэргэшүүлэх хичээл 12 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 12 багц цаг, докторын ажил 24 багц цаг байна. Эрдэм шинжилгээний ажлын 12 багц цагийг харьяалах тэнхимийн даргаар тооцуулж баталгаажуулна.

Дөрөв. Сургалтын агуулга, багтаамж

4.1. Сургалтын агуулга нь батлан хамгаалах, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлал чиглэлээр мэргэжлийн судлаачид, эрдэмтдийн нөөц бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажлын дадлага, туршлага, судалгааны арга зүй эзэмшүүлэхэд оршино.

4.2. Мэргэжлийн магистрын хөтөлбөрөөр суралцах хугацаа 1-2 жил, судалгааны магистрын сургалтын хугацаа 1.5-2 жил, докторын сургалт 2.5-4 жил байна.

4.3. Сургалтын хичээлийн жил нь хоёр улиралтай, улирал тус бүр нь 12-15 долоо хоног байна. Хичээл нь 2, 10 дугаар сард эхэлнэ.

4.4. Магистрант, докторант нь мэргэшүүлэх хичээлийн сонгон суралцах багц цагийг эрдэм шинжилгээний ажлын удирдагчтай зөвлөлдөж, сургалтын календарчилсан төлөвлөгөө боловсруулж, тэнхимийн даргаар хянуулж, Эрдмийн сургуулийн захирлаар баталгаажуулна.

4.5. Гадаад, дотоодын их, дээд сургуулиас шилжин ирэх суралцагчдын судалсан хичээлийг журмын дагуу мэргэжлийн тэнхим дүйцүүлэн тооцож, саналаа ССХАлбанд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.6. Докторын нэгдсэн шалгалтаа амжилттай өгч, гэрчилгээ авсан суралцагчдад докторын зэрэг хамгаалах эрх нээгдэх ба докторын диссертац бичиж, "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл"-д хамгаална

4.7. Магистрант нь магистрын ажил бичиж "Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл"-д хамгаална.

4.8. Батлан хамгаалах удирдлагын академийн сонсогчдын магистрын судалгааны ажлын сэдэв, удирдагчийг тус академиас хэлэлцэж ирүүлсэн саналыг Эрдмийн сургуулийн тэнхимүүдээр хянуулж суралцах хөтөлбөрийг тодорхойлсны үндсэн дээр их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Сонсогчид буюу магистрантууд нь магистрын ажлаа их сургуулийн "Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл"-д хамгаална.

Тав. Хөтөлбөрийн зохион байгуулалт.

5.1. Эрдмийн сургуулийн ССХА нь тэнхим, төвүүдийн оролцоотой сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, сургалтын явцад хяналт тавих, элсэлт, төгсөлтийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.2. Магистр, докторын хөтөлбөрт суралцагчид нь суралцагчийн болон номын сангийн үнэмлэх, сурлагын дэвтэртэй байна.

5.3. Суралцагч суралцах хугацаандаа Эрдмийн сургуулийн ССХА-нд бүртгүүлсэн өөрийн e-mail хаяг болон ҮБХИС-ийн цахим хуудсыг байнга шалгаж байх үүрэг хүлээнэ.

5.4. Магистрант, докторант нь магистрын болон докторын ажлаа ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартын дагуу боловсруулсан байна.

5.5. Зохиох шаардлагыг бүрэн хангасан магистрын ажлын цаасан ба цахим хувийг нууц бичиг хэрэг болон ҮБХИС-ийн Төв номын санд, диссертацийн хувийг Үндэсний номын сан, Шинжлэх ухаан технологийн сан, ҮБХИС-ийн Төв номын санд заавал хүлээлгэн өгнө. Энэ тохиолдолд диплом, энгэрийн тэмдэг олгох эрх үүснэ.

5.6. Төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдгийг ёслол, хүндэтгэлтэйгээр гардуулах ажиллагааг Эрдмийн сургууль зохион байгуулна.

Зургаа. Хичээл заах багш, эрдэм шинжилгээний ажлын удирдагч

6.1. Магистр, докторын сургалт явуулах багшлах бүрэлдэхүүн, эрдэм шинжилгээний ажлын удирдагч нар нь “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын шаардлагыг хангасан байна.

6.2. Магистр, докторын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нь докторын зэрэгтэй байна.

6.3. Магистрын ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, монгол болон бусад улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй, хөндлөнгийн хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн эрдэм шинжилгээний гадаад, дотоодын сэтгүүлд (нууцын зэрэгтэй сэтгүүлд) хэвлүүлсэн бүтээлтэй идэвхтэй судлаачид байна.

6.4. Докторын ажлын удирдагч нь энэхүү журмын 6.3-т заасан шаардлагаас гадна тухайн мэргэжлээрээ сүүлийн 3 жилд хоёроос цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн идэвхтэй судлаач байна.

6.5. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч нь судалгааны ажлын сэдэв тодорхойлох, судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулах, судалгаа явуулахад зөвлөх, тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих, ажлын агуулгыг хэсэгчлэн болон бүхэлд нь дүгнэх, судалгааны ажлын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн ач холбогдол, диссертациад тавигдах шаардлага, диссертаци бичих стандартыг хангаж буй талаар хариуцлага хүлээнэ.

6.6. Магистрант, докторантын удирдагч нь бусад их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, судлаач, салбарын эрдэмтэн байж болно.

6.7. Доктор (Ph.D) нь нэг хичээлийн жилд 3 магистрант, 2 докторант, доктор (Sc.D) нь 3 магистрант, 3 докторантыг удирдана.

Долоо. Сургалтын үнэлгээ

7.1. Магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын мэдлэг чадварыг “ҮБХИС-ийн суралцагчийн үнэлгээний журам”-аар үнэлнэ.

7.2. Суралцагчдын улирлын шалгалтыг мэргэжлийн хичээлийн онцлогоос хамааран тест, ур чадвар, аман болон бичгийн хэлбэрээр зохион байгуулж болно.

7.3. Сургалтад хамрагдаагүй болон улирлын шалгалтад зохих үнэлгээ авч чадаагүй, нэг улирлын 2 хичээлд, мөн 1 хичээлд хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан бол багц цагийн төлбөрийг төлж, тухайн хичээлийг дахин судална.

7.4. Магистрант, докторантын голч дүн 2.7 ба түүнээс дээш байна.

7.5. Докторант нь мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн багц цагийг судалсны дараа гадаад хэлний болон мэргэжлийн нэгдсэн шалгалт өгнө.

Найм. Докторантын мэргэжлийн нэгдсэн шалгалт

8.1. Докторант нь сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийг бүрэн судалсны дараа суралцаж буй мэргэжлийн чиглэлээр нэгдсэн шалгалт өгнө. Тус шалгалтыг 5 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулна.

8.2. Нэгдсэн шалгалтыг ҮБХИС-ийн захирлын тушаалаар томилогдсон комисс авна.

8.3. Докторант нь нэгдсэн шалгалтад орохдоо дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

✓ Сургалтын төлөвлөгөөнд заагдсан багц цагийн хичээлийг бүрэн судалсан байна.

✓ Сургалтын төлбөрийн 50-аас доошгүй хувийг төлсөн байна.

8.4 Нэгдсэн шалгалтад тэнцээгүй докторант дахин 1 удаа шалгалт өгч болно.

8.5 Шалгалтын комисс мэргэжлийн шалгалтын дүн, шалгалт авсан тухай тэмдэглэлийг холбогдох материалын хамт ССХА-д хүлээлгэн өгнө.

8.6 Докторантын шалгалтын нэгдсэн дүнг ҮБХИС-ийн эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал батална.

Ес. Магистрант, докторантын түвшин тогтоох шалгалт

9.1. Эрдмийн сургуулийн тэнхимүүд жил бүрийн 4 дүгээр сард магистрант нарын, 5 дугаар сард докторант нарын тухайн жилд цуглуулсан кредит цаг, сургалт, судалгааны ажлын явцын түвшнийг тогтоох ажлыг зохион байгуулна.

9.2. Магистрант нь сургалт, судалгааны ажлын үр дүнг тайлагнахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

✓ Хичээлийн багц цаг тооцсон, баталгаажуулсан бичилт бүрэн хийгдсэн магистрантын дэвтэр,

✓ Сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийг судалж, үнэлүүлсэн дүнгийн хүснэгт, (ССХА-аас авсан байх)

✓ Эрдэм шинжилгээний хурал, семинарт илтгэл хэлэлцүүлсэн материал (эх хувь)

✓ Сонгосон сэдвийнхээ хүрээнд хийсэн туршилт, судалгааны ажлын явц, биелэлт, үр дүнгийн тайлан,

✓ Тэнхимийн дарга, тэргүүлэх профессорын дүгнэлт,

✓ Удирдагчийн тодорхойлолт (сурлагын дэвтэрт магистрантын идэвх чармайлт, удирдагчтай хамтарч ажилласан байдал, сурах, сургах үйл ажиллагааны үр дүнг тэмдэглэн бичнэ)

9.3. Докторант сургалт, судалгааны ажлыг тайлагнахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

✓ Докторант ССХА-наас сургалтын төлөвлөгөөний дагуу зохих хичээлийг судалж, үнэлүүлсэн дүнгийн тодорхойлолт авсан байх;

✓ Докторантын тухайн жилийн бүтээлийн жагсаалт

✓ Сэдвийн хүрээнд явуулсан туршилт, судалгааны ажлын явц, үр дүнгийн талаарх тайлан;

✓ Удирдагчийн тодорхойлолт (сурлагын дэвтэрт докторантын идэвх чармайлт, удирдагчтай хамтарч ажилласан байдал, сурах, сургах үйл ажиллагааны үр дүнг тэмдэглэн бичнэ)

9.4. Тэнхим нь магистрант, докторант бүрийн сургалт, судалгааны явцын үр дүнгийн тухай бичгээр тайлагнаж, тэнхимийн хурлаар хэлэлцэнэ.

Арав. Магистрын ажил, докторын диссертацийн хамгаалалт

10.1. Магистр, докторын судалгааны ажлын явц нь дараах үе шаттай байна. Үүнд: Сэдэв, эрдэм шинжилгээний ажлын удирдагч, тэнхим томилох, судалгааны ажлын явцын болон өргөтгөсөн хэлэлцүүлэг, урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт.

10.2. Элссэн эхний жилд магистрант, докторантын судалгааны ажлын сэдэв, түшиц тэнхим, эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг их сургуулийн захирлын тушаалаар батална.

10.3. Тус журмын 4.8-д зааснаас бусад магистрантын судалгааны ажлын сэдэв, эрдэм шинжилгээний удирдагч, түшиц тэнхимийг сонгох асуудлыг тэнхимүүдийн өргөтгөсөн хурлаар, тэдгээрийг нягтлан шүүж батлах, саналаа ҮБХИС-ийн захиралд уламжлах, эсэх асуудлыг Эрдмийн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцэнэ.

10.4. Докторантуудын судалгааны ажлын сэдэв, эрдэм шинжилгээний удирдагч, түшиц тэнхимийг сонгох асуудлыг тэнхимүүдийн өргөтгөсөн хурлаар, тэдгээрийг нягтлан шүүж батлах, саналаа их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэнэ.

10.5. Магистрант, докторант нь судалгааны ажлын сэдэв, удирдагчийг өөрчлөх тохиолдолд зөвхөн 1 удаа үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр үйлдэж, тэнхимийн даргаар уламжлан, магистрант нь Эрдмийн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар, докторант нь их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

10.6. Магистрант, докторант нь судалгааны ажлын явц болон үр дүнгээр монгол болон бусад улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй, хөндлөнгийн хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн эрдэм шинжилгээний гадаад, дотоодын сэтгүүлд (нууцын зэрэгтэй сэтгүүлд) нэгдүгээр зохиогчоор 2-аас доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн болон эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байна.

10.7. Магистрант, докторант нь урьдчилсан хамгаалалтад орохоос өмнө нууцын дүгнэлт гаргуулсан байна.

10.8. ССХА-ны чиглэл хариуцсан мэргэжилтэн нь магистрантын урьдчилсан хамгаалалтад орохыг хүссэн өргөдөл, бусад бүрдүүлсэн материалын хамт хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө. /НБД нь зөвлөлийн даргатай зөвшилцөж урьдчилсан хамгаалалтын өдрийг товлон.

10.9. Докторант 20 кредит цаг судалж дуусахаас өмнө докторантын судалгааны ажлын сэдэв, удирдагчийг Эрдмийн сургуулийн тэнхимээр хэлэлцүүлж гаргасан саналыг их сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. /Удирдагчаар бүтээлийн жагсаалтыг харгалзан, сэдэвтэй холбоотой мэргэжлийн хүн томилно./

10.10. Докторантад тухайн хөтөлбөр хэрэгжүүлж буй тэнхимийн саналаар судалгааны ажлын сэдвийн чиглэлтэй уялдуулан зөвлөх багийг байгуулах бөгөөд докторантын удирдагч зөвлөх багийг ахална. Зөвлөх баг нь гурван хүний бүрэлдэхүүнтэй нэг гишүүн хамтран удирдагч байж болох, мөн тухайн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тэнхимээс профессор багш нараас зөвлөх багаар томилж болно.

10.11. Докторант бүрээр диссертацийн сэдвийн чиглэлтэй уялдуулан тухайн хамгаалуулах зөвлөлийн долоон гишүүний төлөөлөлтэй Дэд зөвлөлийг байгуулна. /хавсралт №1 докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөл байгуулах тухай зөвшилцөх хуудас/

10.12. ССХА-ны чиглэл хариуцсан мэргэжилтэн нь докторантын урьдчилсан хамгаалалтад докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийн 4.3-д заасны дагуу бичиг баримтыг бүрдүүлж хамгаалуулах дэд зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө.

10.13. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга баримт бичиг хүлээж авснаас хойш ажлын долоон өдрийн дотор урьдчилсан хамгаалалтын хоёр шүүмжлэгчийг Дэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нартай хэлэлцэж томилно.

10.14. Урьдчилсан хамгаалалтын албан ёсны шүүмжлэгчийг үндсэн зөвлөлийн гишүүдээс нэг, байгуулагдсан дэд зөвлөлөөс нэг гишүүн тус тус томилно.

10.15. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга докторантын зөвлөх багийн хамтын шийдвэрийг диссертацийн сэдэв, зорилго, үр дүн, судалгааны арга зүй, явц үр дүнг хэлэлцсэн зөвлөх багийн хуралдааны тэмдэглэлтэй хамт хүлээж авснаар зөвлөлийн даргатай зөвшилцөж урьдчилсан хамгаалалтын өдрийг товлон. /хавсралт №2, зөвлөх багийн хамтын шийдвэрийн загвар /

Арван нэг. Суралцагчдын шилжилт, чөлөө олгох, сургалтаас хасах

11.1. Дотооддоо хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргасан суралцагчийн асуудлыг судалгааны ажлын удирдагчийн санал, тухайн түшиц тэнхимийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн шилжүүлнэ.

11.2. Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаад ҮБХИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан магистрант, докторантыг Эрдмийн сургуулийн тэнхимийн саналыг үндэслэн сургаж болно.

11.3. Суралцагчийн хөтөлбөрийн гүйцэтгэлд тухайн сургуульд биелүүлсэн 12 хүртэл багц цагийг дүйцүүлэн тооцож болно.

11.4. Шилжин суралцах хүсэлт гаргасан суралцагч нь өргөдөл, төрийн албан хаагчийн анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, суралцаж буй сургуульд элсэн орсон тухай тушаалын хуулбар, сурлагын тодорхойлолт (судалсан хичээлийн нэр, багц цаг, шалгалтын дүн), суралцагчийг шилжүүлсэн тухай тухайн сургуулийн албан

бичиг, шилжин суралцахыг зөвшөөрсөн тухай Эрдмийн сургуулийн тэнхимийн зөвшөөрөл зэргийг бүрдүүлнэ.

11.5. Бусад сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргасан суралцагч тухайн жил, улирлын сургалтын төлбөрөөс гадна кредитийн зөрүү болон шилжилтийн төлбөр төлнө.

11.6. Суралцагч нь сургалтын хугацаанд ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх шалтгаанаар нэг жилийн чөлөөг нэг удаа авч болно. Үргэлжлүүлэн суралцах боломжгүй тохиолдолд жилийн чөлөөг сунгах, дахин олгох хүсэлтийг албан бичгээр гаргасныг үндэслэн үргэлжлүүлэн олгож болох ба чөлөөтэй байх нийт хугацаа 5-6 улирлаас хэтрэхгүй болно.

11.7. Суралцагчийг сургалтын төлбөрөө тогтоосон хугацаанд төлөөгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр нэг улиралд 36-аас дээш цагийн хичээл тасалсан, нэг жилийн чөлөөний хугацаа дууссан боловч эргэн холбогдоогүй эсхүл суралцаагүй, хууль тогтоомж, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, хугацаандаа хамгаалаагүй зэрэг нь сургуулиас хасах үндэслэл болно.

11.8. Сургалтын багц цагийг бүрэн судалж, гэрчилгээ авсан докторант 4 жил, магистрант 3 жилд хамгаалаагүй тохиолдолд сургуулиас хасах үндэслэл болно.

11.9. Сургуулиас хасагдсан тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

Арван хоёр. Сургалтын төлбөр

12.1. Суралцагч нь сургалтын төлбөр төлснөөр суралцах эрх баталгаажна.

12.2. Магистрант, докторант нь урьдчилсан хамгаалалтад орох болзол хангасан нөхцөлд сургалтын төлбөрийн хөнгөлөлт хүсэх эрх үүснэ.

12.3. Магистр, докторын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтын зардлыг суралцагч хариуцна.

12.4. БХЯ-ны захиалгаар сурч буй суралцагч хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаандаа хамгаалаагүй тохиолдолд сургалтын төлбөрийг нөхөн төлснөөр хамгаалах эрх нээгдэнэ.

Арван гурав. Гадаадын иргэнийг суралцуулахтай холбоотой нэмэлт заалт

13.1. Гадаадын иргэд ахисан түвшний хөтөлбөрөөр суралцаж болно.

13.2. Гадаадын суралцагч нь монгол хэлээр сургалтад хамрагдах шаардлагыг хангасан байна.

13.3. Хоёр улсын гэрээний үндсэн дээр ахисан түвшний боловсрол эзэмшихээр ирсэн гадаадын суралцагчид зориулсан тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирлын шийдвэрийг үндэслэн зохион байгуулна.

ЭРДМИЙН СУРГУУЛЬ

**ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛУУЛАХ ДЭД ЗӨВЛӨЛ
БАЙГУУЛАХ ТУХАЙ ЗӨВШИЛЦӨХ ХУУДАС**

....оны ... дугаар сарын ...-ны өдөр.

Улаанбаатар хот

Докторантын овог, нэр _____

Диссертацын сэдэв: _____

№	Хамгаалуулах зөвлөлийн даргын санал	Удирдагчийн санал	Ахисан түвшний сургалт хариуцсан нэгжийн дарга	Нэгтгэсэн санал	Харьяалал
1					ҮБХИС
2					ҮБХИС
3					ҮБХИС
4					Бусад ИС, байгууллага
5					Бусад ИС, байгууллага
6					Бусад ИС, байгууллага
7					Бусад ИС, байгууллага
Диссертац салбар дундын сэдэвтэй бол Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөсөн гишүүд					
1					
2					

ЗӨВШИЛЦСӨН:

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА/...../

2024 оны сарынны өдөр

АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТ ХАРИУЦСАН НЭГЖИЙН ДАРГА

...../...../

2024 оны.... сарынны өдөр

ДОКТОРАНТЫН УДИРДАГЧ/...../

2024 оны.... сарынны өдөр

ЗӨВЛӨХ БАГИЙН ХАМТЫН ШИЙДВЭР

....оны ... дугаар сарын ...-ны өдөр.

Улаанбаатар хот

Докторантын овог, нэр _____

Диссертацийн сэдэв: _____

№	Зөвлөх багийн бүрэлдэхүүний нэр	Эрдмийн зэрэг, цол	Албан тушаал	Докторантын диссертацийг урьдчилсан хамгаалалтанд оруулахаар материалыг хүргүүлэх эсэх санал ("тийм", үгүй")
1			Ахлагч	
2			гишүүн	
3			гишүүн	

Жич: Зөвлөх багийн шийдвэрийг диссертацийн сэдэв, зорилго, үр дүн, судалгааны арга зүй, явц үр дүнг хэлэлцсэн зөвлөх багийн хуралдааны тэмдэглэлтэй хамт ирүүлнэ. (Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3.4-д заасан үндэслэл)

ЗӨВЛӨХ БАГИЙН ШИЙДВЭР:

1. Зөвшөөрсөн /Тийм/..... хувь
2. Татгалзсан /Үгүй/хувь

Зөвлөх багийн шийдвэр

ЗӨВЛӨХ БАГИЙН АХЛАГЧ _____/...../

1. ГИШҮҮД _____/...../

2. ГИШҮҮН _____/...../

ЭРДМИЙН СУРГУУЛЬ